Коронавируст халдвар (COVID-19)-ын үеийн чихрийн шижингийн тусламж үйлчилгээ

Х.Алтайсайхан, Д.Гангаамаа, Б.Оюунтөгс, Г.Нархажид, Т.Баясгалан, Б.Болор, Б.Анхлан, Ж.Сувд, С.Сайнбилэг

АШУҮИС-ийн АУС-ийн Дотоод шүүрэл судлалын тэнхим
altaisaikhan@mnums.edu.mn, 99901691

ТОВЧ УТГА

Олон улсын чихрийн шижингийн холбооны боловсруулсан "SICK DAY RULES" буюу коронавирүст халдварын үед баримтлах чихрийн шижингийн тусламж үйлчилгээний удирдамжийг ДЭМБ мөрдөж ажиллахыг зөвлөсөн. Энэхүү удирдамж нь Короновируст халдварын цар тахлын хөл хорио тогтоосон үеийн төлөвлөлт зохион байгуулалт, чихрийн шижин хэвшинж-1-ийн эмчилгээ хяналт, чихрийн шижин хэвшинж-2-ын эмийн ба инсулины эмчилгээхяналтын талаарх зөвлөмжийг багтаасан. АШУҮИС-ийн АУС-ийн Дотоод шүүрэл судлалын тэнхим энэхүү удирдамжийг орчуулан Чихрийн Шижинтэй Тэмцэх Үндэсний Төв болон Эрүүл Мэндийн Яамны Дотрын Анагаахын Салбар зөвлөлийн мэргэжилтнүүдээр хэлэлцүүлсэн болно.

Keywords: Короновирус, чихрийн шижин, тусламж үйлчилгээ

Чихрийн шижин ба халдвар

Чихрийн шижин (ЧШ)-тэй хүмүүс халдварт өртөх өндөр эрсдэлтэй тул Олон улсын чихрийн шижингийн холбоо (IDF) – ноос "SICK DAY RULES" буюу коронавирүст халдварын үед баримтлах ЧШ-ийн тусламж үйлчилгээний удирдамж гаргаж ДЭМБ тус удирдамжийг мөрдөж ажиллахыг зөвлөсөн. ЧШ-тэй хүмүүс ханиад хүрэх зэрэх хурц өвчнөөр өвдсөн үед дотоод шүүрлийн булчирхайнууд их хэмжээний даавар ялгаруулснаар цусны глюкоз огцом нэмэгдэнэ. COVID-19 болонтомуу, томуу төст өвчин, хоолой өвдөх, давсаг бөөрний үрэвсэл, бронхит болон уушигны хатгалгаа, хоолны хордлого, гүйлгэх, хатиг болон арьсны идээт үрэвсэл зэрэг өвчний үед өндөр халуурч, шингэн алдснаар цусны глюкоз огцом нэмэгдэж үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүсэж болно. ЧШ-тэй хүмүүс хурц халдварт өвчнөөр өвдснөөр цусны глюкоз огцом нэмэгдэм кетоацидоз болон комд орох эрсдэлтэй.

Төлөвлөлт, зохион байгуулалт

Короновируст халдварын үеийн төлөвлөлт зохион байгуулалтыг дараах байдлаар хийж гүйцэтгэхийг зөвлөмж болгосон. Үүнд:

1. Чихрийн шижинтэй хүмүүс, чихрийн шижинтэй хүүхдүүдийн эцэг эхчүүд эмч мэргэжилтнүүдтэйгээ зөвлөн хөл хорионы үед эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрхэн авах талаар төлөвлөгөө гаргах
2. Цусны сахараа хянах зорилт түвшинг тогтох
3. Сахар бууруулах эм, инсүлины тунг хэрхэн тохирлуулах талаар зөвлөгөө авах
4. Хэзээ, хэнээс, ямар утсаар зөвлөгөө авахаа тогтох
5. Цусны глюкоз болон кетоныг ямар хугацаанд үзэх, тэмдэглэл хөтлөх

Мөн дараах тохиолдолд яаралтай эмнэлэгт хандахыг анхааруулна. Үүнд:

1. Цусны глюкоз 15 ммоль/л –ээс дээш болсон, шээсэнд кетон нэмэх гарсан, ам хатах, бөөлжих, амьсгал давчдах, хэвлийгээр өвдөх, ухаан балартах зэрэг шинж илэрвэл хамгийн ойр эмнэлэгт хандаж яаралтай тусламж авах
2. Цусны глюкоз 24 цагийн турш буурахгүй тогтвортой өндөр эсхүл юу хийхээ мэдэхгүй байвал дотоод шүүрлийн эмчээс зөвлөгөө авах.

Чихрийн шижинтэй хүмүүсийн мөрдөх дэглэм

1. Сахар бууруулах эмээ тогтсон тунгаар тогтмол хэрэглэх
2. Инсүлин эмчилгээг ОГТ ТАСАЛЖ БОЛОХГҮЙ
3. Өвдсөн үедээ цусны сахараа 4 цаг тутам үзэж тэмдэглэл хөтлөх

4. Тогтмол цагт хооллож, шингэн сайн уу
5. Биеийн жингээ өдөр бүр хэмж, жингээ алдаж байвал эмчээс зөвлөгөө ав
6. Биеийн халуунаа өглөө, орой тогтмол үз
7. 2 цаг тутам 120-180 мл ус, шингэн юм уу
8. Өдөрт 50гр нүүрс ус хоол хүнсээрээ авч чадахгүй байгаа бол жимсний шүүс зэрэг сахар агуулсан шингэн уугаарай

Чихрийн шижин хэв шинж-1-ийн эмчилгээ, хяналт

1. Инсүлин эмчилгээг ОГТ ТАСАЛЖ БОЛОХГҮЙ
2. Цусны глюкоз, шээсэнд кетон үзэх түргэвчилсэн оношлуур,багажийн хэрэгслэлийн хамт бэлтгэх
3. Шаардлагатай тохиолдолд зөвхөн богино үйлчилгээтэй инсүлины тунг нэм
4. Цусны глюкозыг 4 цаг тутам үзэж тэмдэглэл хөтөл
5. Шингэн алдалтаас сэргийлж сахар агуулаагүй шингэн сайн уу
6. Цусны глюкозынзорилтот түвшин6-10 ммоль/л (110-180 мг/дл) байх
7. Цусны глюкоз 15 ммоль/л ээс дээш, шээсэнд +++ илэрсэн тохиолдолд яаралтай эмнэлэгт ханд
8. Ханиад томуу, идээт халдвар, хордлого болсон үед инсүлины тунг 4-6 нэгжээр нэмэгдүүлж хоногт (24цаг) хийх инсүлины(сууриь болон богино үйлчилгээтэй инсүлины нийт тун) **ХИТ** тогтоо
9. Хүснэгт 2 дагуу цусны глюкоз, шээсэн дэх кетоны түвшинтэй уялдуулан хоногт хийх инсүлины тунгийн **(ХИТ)** –ийн 10% ----, 15% ------, 20% ------ д ногдох нэмэлт инсүлины тунг **(НИТ)** тооцоол
10. Нэмэлт инсүлины тунгаар **(НИТ)** богино болон хэт богино үйлчилгээтэй инсулиныг 4 цаг тутам арьсан дор тарь
11. 4 цаг тутам инсүлин эмчилгээ хийхээс өмнө цусны глюкоз болон шээсний кетон үзэж Хүснэгт 2 дагуу инсүлины тунг тохируул
12. Хоолонд дургүй эсхүл бага идэж байгаа бол жимсний шүүс зэрэг сахартай шингэн уулга

Хүснэгт 1. Цусны глюкозын хяналт ба инсүлин

Цусны глюкозын түвшин	Инсүлины тун	Хяналт
10-15 ммоль/л (180-270 мг/дл)	Хүснэгт 2 дагуу зохих тунгаар нэмэх	2-4 цаг тутам хянах
>15 ммоль/л (270 мг/дл) ээс дээш	Хүснэгт 2 дагуу зохих тунгаар нэмэх	2 цаг тутам хянах

Хүснэгт 2. Нэмэлт инсүлины тунг (НИТ) тохируулах

Цусны глюкоз (ммоль/л [мг/дл])	Шээсний кетон	Инсүлин эмчилгээ ба авах арга хэмжээ
<3.9 [70]	-	Нэмэлт инсулин шаардлагагүй. Богино үйлчилгээтэй инсүлины тунг хэвээр үргэлжлүүл **Бөөлжвөл яаралтай эмчэд хандаарай!**
4.0-16.0 [72-288]	-/+	Хэвийн үед хэрэглэж байсан инсүлин эмчилгээг хэвээр үргэлжлүүл
4.0-16.0 [72-288]	+	ХИТ-ийн10 % тэнцэх тунгаар богино үйлчилгээтэй инсүлин нэмэлтээр ав
>16 [288]	-/+	ХИТ-ийн10 % тэнцэх тунгаар богино үйлчилгээтэй инсүлин нэмэлтээр ав
>16 [288]	++	ХИТ-ийн 15 % тэнцэх тунгаар богино үйлчилгээтэй инсүлин нэмэлтээр ав
>16 [288]	+++	ХИТ-ийн 20 % тэнцэх тунгаар богино үйлчилгээтэй инсүлин нэмэлтээр ав. **Яаралтай эмчтэйгээ холбоо бариарай!**

Чихрийн шижин хэв шинж 2-ын эмийн эмчилгээ

1. Ам хатах, их хэмжээгээр шээх, ядрах, турах зэрэг шинж нь цусны глюкоз ихэссэны дохио
2. Хэрэв метформин ууж байгаа бол ханиад томуу хүрсэн, халдвар хордлогын шинж илэрсэн, шингэн алдсан үед түр эмээ зогсоо
3. Хэрэв метформин эмийг зогсоох шаардлагатай бол глимепирид, гликлазид эсхүл суурь инсүлинээр орлуул
4. Эмээ сольсон тохиолдолд гипогликеми ээс сэргийлэх зорилгоор цусны глюкозыг өдөрт 2 оос доошгүй удаа үзэж тэмдэглэ
5. Хурц өвчний үед цусны глюкоз нэмэгдэх эрсдэлтэйг анхаар
6. Цусны глюкозын зорилтот түвшин6-10 ммоль/л (110-180 мг/дл) байх

Чихрийн шижин хэв шинж 2-ын инсүлин эмчилгээ

1. Цусны глюкозын зорилтот түвшин6-10 ммоль/л (110-180 мг/дл) байх
2. Цусны глюкозыг өдөрт 2 оос доошгүй удаа үзэж тэмдэглэ
3. Цусны глюкоз 10 ммоль/л дээш болсон үед инсүлины тунг нэм
4. Цусны глюкоз 15 ммоль/л дээш болсон үед 4 цаг тутам цусны глюкоз, шээсэнд кетон үзэж тэмдэглэ
5. Цусны глюкоз 15 ммоль/л дээш, шээсэнд кетон илэрвэл яаралтай эмнэлэгт ханд

Эх сурвалж: COVID-19 and Diabetes, International Diabetes Federation

Diabetes management for coronavirus (COVID-19) infections

Altaisaikhan Kh, Gangaamaa D, Oyuntugs B, Narkhajid G, Bayasgalan T, Bolor B, Ankhlan B, Suvd J, Sainbileg S

Department of Endocrinology, School of Medicine, Mongolian National University of Medical Sciences
altaisaikhan@mnums.edu.mn, 99901691

The World Health Organization (WHO) issued “SICK DAY RULES” guidelines for coronavirus infections (COVID-19) which were developed by the International Diabetes Federation for diabetic management. These guidelines include management for the planning and management of the coronavirus epidemic quarantine, oral glycemic agents and insulin treatment, and monitoring for type 1 and type 2 diabetes. The Department of Endocrinology of School of Medicine, Mongolian National University of Medical Sciences, translated the guidelines and reviewed them with experts from the Mongolian Diabetes Association and the Ministry of Health.